

МАНЖИЙН ХААД ТУЙЛД ХҮРСЭН НЬ

Э. Мөнх-Учрал *

Оршил

Дайчин улс (1644-1911) Хятад дахь хамгийн сүүлийн угсаа залгамжлах хаант улс, хамгийн удаан хугацаагаар Хятадад төвлөн сууж, олон улс үндэстнийг эрхшээн захирсан гэдгээрээ түүхэнд үлдсэн билээ. Таван зууны тэртээ Алтан улс (1115-1234)-ыг байгуулж асан жүрчидийн хойчис дахин хүчирхэг төр улсыг засаж чадсан явдал, тодруулбал, Мин улсын үеийн (1368-1644) хил хязгаарыг цагдан сэргийлэх нэгж буюу *вэй* (хя. 衛 *wei*)-гийн нэг болох¹ Жяньжоу харуулын аймаг (хя. 建州 *Jianzhou*)² хятад, монгол, төвд, уйгурыг яаж эзлээд, хэрхэн захирсныг ойлгон тайлбарлах асуудал олон судлаачдыг соронзон мэт татсан нь Чин судлалын салбарыг хэдийнээ бий болгожээ.

Чин судлалд манжийн түүхийг монголоос ангид судлах боломжгүйг зөвшөөрдгийн дотор цолын тухай асуудал зүй ёсоор багтдаг. Тиймээс, манж нар эхэн үедээ алдар гавьяа байгуулсан нэгнээ монгол нэр цолоор өргөмжилдөг байсныг болон Нурхачид монголчуудын өгсөн "*Сэцэн хүндэн хан*" цол чухлаар нөлөөлснийг манж судлалын маш олон бүтээл дурдаж ирсэн билээ. Тэд мандан бадрах үедээ монголчуудыг хуваахын зэрэгцээ язгуурын ёсоор нь захирах бодлогын хослол дээр, нэгдмэл хүчгүй атлаа манжийн хяналтаас тасрахааргүй хүлэгдсэн Монголыг бүтээх арга хэрэгсэл болгон хэргэм зэргийн бүхэл бүтэн тогтолцоо нэвтрүүлж ашигласан юм. Тодруулбал, Энх-Амгалан хаан 1691 онд халхын ноёдод зэрэг зохиохдоо, *хунтайж, жонон, чинсан, үйзэн, хошууч, дайчин, дүүрэн, өрлөг, цоохуур* цолыг хасаж, *хан, ван, тайж* мэтийг үлдээж, ван, бэйл, бэйс, гүн тэргүүтэй хэргэм олгожээ. Монголын зарим цолыг хассан буюу үлдээсэн энэ явдал энгийн учиртай байж болох юм. Нэгэнт хоёр талд хэдийн танил болсон цолнуудаас Дайчин улсын хэргэмийн тогтолцоотой таарч байсан нь

* МУИС-ийн МХСС-ийн Эх бичиг судлалын тэнхим

¹ Franz Michael, *The Origin of Manchu Rule in China*, Frontier and Bureaucracy as Interacting Forces in the Chinese Empire, Octagon books.INC., New York, 1965, pp. 25-39.

Жич, тус өгүүлэлд Вэйд-Жайлз /*Wade-Giles*/ галигийг бус, түгээмэл хэрэглэдгээр нь Пиньинь тогтолцоо /*Pinyin system*/ -г баримталаа.

² Латтимор "*Жяньжоу*" нэрийг "*Жиний овог*" буюу "*Жиньзү*"-гийн гажуудсан хэлбэр байж магадгүй гэж үзсэн байдаг. Горьский Нурхачийг Жинь улсын хунтайжийн арван үеийн шууд хойчис гэжээ. Тэд өөрсдийгөө 1635 оноос л "манж" хэмээн нэрлэсэн. Owen Lattimore, *Inner Asian Frontiers of China*, American Geographical Society, Research series No. 21, New York, 1951, p.116, n.29; Henry Serruys, *Sino-Tibetan Relations During the Yung-Lo Period*, (1403-1424), Guttinger Asiatische Forschungen, Band 4, Otto Harrasowitz, Wiesbaden, 1955, pp.28-41; Franz Michael 1965, p.39, n.1, 2; *Jiu Manzhou dang* (舊滿洲檔, *Дусал бинтгүй үсгийн данс*), Vol.IX, Taipei, Palace Museum, 1969, p.4509.

ашиглагдаж, тэнд багтаагүй нь хасагдсан. Хятад хэлнээс ормол *хунтайж* (хя. 皇太子 *huang taizi*) бол хааны хүүг заах бөгөөд дараагийн хаанаар өргөмжлөгдөх утгыг агуулдаг.³ Нэг улсын дотор гагцхүү манжийн хааны хүү *хунтайж* хэмээн нэрлэгдэх учиртай, тиймээс уг цолыг Монголд байлгах нөхцөлгүй. Тэгтэл, ийм зарчмаар үзвээс *хан* цол Монголд хадгалагдах үндэслэлгүй баймаар.⁴

Тиймээс, энэхүү өгүүлэлд, *нэгд*, Монголыг эрхшээснийхээ дараа Халхад хан байхыг юун учир зөвшөөрсөн болохыг, *нөгөө* нь манжийн бэйл монголчуудад цол олгох эрхтэй хамгийн дээд хаан болоход монгол цолын уламжлал хэрхэн нөлөөлсөн болох гэсэн хоёр асуудлыг Чингийн шинэ түүхийн хандлагаар авч үзэх болно.⁵

Бэйлээс Хуанди хүрсэн нь

Дайчин улсын язгууртнуудын чухал бүрэлдэхүүн хэсэг болох монгол, манж язгууртнууд эртний улсуудын удирдагчдын хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний ёсоор ноёлогч нэг удмаас гаралтай. Монголын язгууртан наашлуулахад Бодончар мунхагаас үүдэж, Их Монгол улсын Чингис хааны эцэг Есүхэйн талын Хиад яст Боржигин овгийнхныг (мо. *Kiyad borjigin*) хамаарч, *алтан ураг* хэмээн нэрлэгддэг бол манжийн язгуур угсаа Алтан улсын Нурхачи хааны өвөг эцэг Гиочанга, эцэг Тагсигаас эхэлж, тэдний *Айсин гиоро* (ма. *Aisin gioro*, хя. 愛新覺羅 *Aixin jueluo*) овгийнхныг багтаадаг. Энэхүү хоёр өөр угсааныхан Дайчин улсын захиргаанд нэгдсэн үеэсээ эзэнт гүрний мөхөл хүртэл хэргэм зэргийн нэг тогтолцоонд хамрагдсан. Харин ийм цолын ижилсэлд хүрсэн замын чиглэл ялгаатай.

XVI зууны сүүлээр Чингисийн удмынхан удам залгасан *хан* байж, харьяат аймгаа захиран ахуйд, Нурхачи *бэйл* цолтойгоор гарч ирэв. Тухайн цагт манжийн *бэйл* цолтон монголын ноёнтон дүйж байлаа.⁶ Энэ цэгээс монголын хан, манжийн ноён хоёул

³ Гэвч, XVII зууны үед Чингисийн удмын бус, Ойрдын тэргүүлэх язгууртан хунтайж цолтойгоор Зүүнгарыг удирдаж асан. Энэ тухайд Даян хааны хунтайж Ойрдыг захирч байснаас ирэлтэй гэдэг. Junko Miyawaki 1987, 1990; Christopher P. Atwood, *Titles, Appanages, Marriages, and Officials: A comparison of Political Forms in the Zhyngar and Thirteenth-Century Mongol Empires*, in D. Sneath (ed.), *Studies on East Asia*, Vol.26, Imperial Statecraft: Political Forms and Techniques of Governance in Inner Asia, Sixth-Twentieth Centuries, 2006, pp.211-14.

⁴ Бадаргуулт төрийн сүүлчийн үеийн Гадаад Монголын зэрэг цолтой хүмүүсийн бүртгэлээр, Өвөр монгол, Хөхнуур, Алшаа, Эзнээд хан байхгүй, харин Ар монголд 3, Дөрвөдөд 1, Торгуудад 1, нийт 5 хан байв.

⁵ *Чингийн шинэ түүх* (New Qing History) хэмээх нэр томъёогоор XX зууны хятад төвт юм уу ангийн үзлээс хэдийн ангижирч, манж хэлээрх архивын баримтуудад түшиглэн, манж нарыг жинхэнэ төрхөөр нь шинжлэхийг буюу манжийн ялгарах шинж - *ижилсэл* (Manchu identity)-ийг өргөн хүрээнд сөргүүлэн дэвшүүлдэг болсон сүүлийн үеийн судалгааны чиг хандлагыг ойлгож болно. Ruth Dunnell, James A. Millward, Introduction, *New Qing Imperial History, The Making of Inner Asian Empire at Qing Chengde*, eds. James Millward et al., Routledge Curzon, London, New York, 2003. pp.1-12.

⁶ "Дусал бинтгүй үсгийн данс" (ДБҮД) -ны бичлэгт манжийн *бэйл*, монголын ноён (*ноуан*) хоёрыг дүйлгэн орчуулдаг. Жишээ нь, манжаар үгчлэн орчуулбал "Сүбүди цагаан хэрэм орж дагасан хятадыг уулгалмуй хэмээн сонсоод хоёр бэйлийн зарсан үг" гэсэн бол монгол хувилбар нь "Хоёр ноёны бичиг. Сүбүдид илгээв" гэж буй. *Jiu Manzhou dang*, 1969, pp. 3069-3070. Ийм орчуулга Монгол бичгийн гэрийн дансны баримтаар, хожим 1691 онд халхын ноёдын цол солигдох хүртэл үзэгддэг. *Dayicing gьrьн-ь Dotuyadu yamun-u Mongyol bičig-ьn ger-ьn dangsa*, I-XXII, Arad-un yeke surayuli-yin Ulus-un Tцb aziy-a-yin kele тьке sudulqu

мандал буурлын эсрэг чигт явж, нэг нь *хуанди* болон дэвших зуур нөгөө нь хэдий нэр хэвээр авч, ноёны энтэй үлдсэн түүх бичигдэнэ. Үүнийг доор задлан үзсүү.

Бэйл (мо. *beyile*, ма. *beile*, хя. 貝勒 *bei le*) бол Чингийн хэргэмийн дотор вангийн дараа орох гуравдугаар зэргийн хэргэм авч, анх хавьгүй өндөр байр суурьд байсан билээ. Хэлшинжлэлийн үүднээс, жүрчиний аймгийн тэргүүлэгчийг заасан *bojile* (<bogile< begile<begin), цаашлаад алтай хэлний *beki~beg~bek* зэрэгтэй холбож үздэг тус цолын гарал нэлээд эртний болохыг харуулна.⁷ Нурхачи анх өвөг эцэг болон эцгээ алагдсаны өсөөр Никан вайланыг дарж, эрэмшин ойр жижиг бүлгүүдийг нэгтгээд, үйл хэргээ Жяньжоугийн *бэйлээр* эхэлсэн. Бэйл тэр үеийн жүрчиний хамгийн дээд цол байсан бол⁸ түүнээс дээших *хан*, *хуанди* нь тус бүртээ монгол, хятадын эзэмшилд байв. Айсин гиоро овгийн угсаа гарлын домогт хүртэл эзнээ “*бэйл*” (ма. *beile*)-ээр эхэлж бичдэг нь үүний нэгэн нотолгоо болох юм.⁹ Төдий удалгүй, 1606 онд халхын ноёд Нурхачийг *Сэцэн хүндлэн хан* (ма. *Sure kundulen han*) нэрийдэв.¹⁰ Уг цол түүнийг хэрхэн түлхэж өгснийг, холбоондоо нэгтгэж чадаагүй сүүлийн аймаг болох Мингийн дэмжлэгээр тогтож байсан Хулуныг дараад, 1616 онд жүрчиний аймгийн холбооны “*хан* цолтой *хаан*” (ма. *han*) болсон үйл явдал харуулна. Одоо Нурхачийн тулж ирсэн дайсантай эргэх замгүй байлдаж байсан хамгаалах байр суурь довтлох зам руу орох боломжтой болж ирсэн. Ингээд Михайл Франц (Michael Franz)-ын онож тэмдэглэсэнчлэн Нурхачи “анх байгаагүй хааны хүсэл эрмэлзлийн хөтөлбөрийг эхлүүлж, “хоолны” дуршил нь нэмэгджээ”.¹¹

Манжийн түүхэнд хаан буй болсноор, бэйл доошлох нь гарцаагүй боловч, үнэндээ, хэсэг хугацаанд хүч нөлөөгөө хадгалсан. Учир нь, Нурхачийн ах дүү, хөвгүүд бэйл болон хошой бэйл цолтойгоор төрийг хамтран засаж, хааны шадар түшиг болж байв. *Хошой бэйл* (ма. *hošoi beile*) нь бэйл цолоос илүү эрхэм бөгөөд Нурхачи хаан болмогцоо дөрвөн хөвгүүнээ хошой бэйл болгосноос үүдэлтэй.¹² Харин Хунтайж¹³ хаан сууринд

kyriyeleng, I-XIII debter, МАКQ, 2005; *Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс*, I-XI, Эрхэлсэн Ш. Чоймаа нар, Соёмбо принтинг, Улаанбаатар, 2010.

⁷⁾ М. Баярсайхан, *Жүрчин ба манжийн зарим цол хэргэмийн учир*, Солонгосын балар эртний соёл, гарал үүслийн асуудал, хурлын эмхтгэл, Улаанбаатар, 2008, т. 23-26.

⁸⁾ Evelyn Rawski, *The Last Emperors: A Social History of Qing Imperial Institutions*, Berkeley, CA: University of California Press, 1998, p. 76.

⁹⁾ *Daičing gurun-i Taizu horongyo enduringge hüwangdi-i yargiyan qooli* (Дайчин улсын Тайзү сүр жавхлант богд хуандийн магад хууль), jai debtelin; 愛新 觉罗, 乌拉春, 滿族古神話 (Манжийн эртний үлгэр), 内蒙古人民出版社, 呼和浩特 1987.

¹⁰⁾ *Eminent Chinese of the Ch'ing Period*, (1944-1912), ed. Arthur Hummel, Literature House, Taipei, 1964, p. 596. “Хүндлэн” цолын утга нь хүндлэх дээдлэхтэй хамаатай. М. Баярсайхан, *Монгол, манж албан бичгийн харьцаа*, Acta Mongolica Tom 7 (291), Улаанбаатар, 2007, т. 157, з. 8.

¹¹⁾ Franz Michael 1965, p. 44

¹²⁾ Манж хэлний *хошо* нь зовхис, өнцөг гэсэн утгатай. Тус цолыг Пеллио, Хауэр нар нэмэлт чимэг гэж орчуулсан бол Хэниш хятадын *fang* (өнцөг гэсэн утгатай)-ийн орчуулга байж магадгүй гэж үзсэн. Франц үүнийг зөв бол манжийн хэлбэржил дэх хятад нөлөөний өөр нэг жишээ болно гэж саналаа илэрхийлсэн. Памела Кроссли хожмын сурвалжуудад дөрвөн хошой бэйл байсан гэдгийг үгийн үндсэн утга болон бөө мөргөлийн найман зовхисын бэлгэдэлтэй уялдуулан найм байсан гэдэг. Энэхүү манж гаралтай холбосон тайлбарыг хувьдаа зөвшөөж байна. Erich Haenisch, *Hošoi cin Wang*, Asia Major 3, Harrassowitz, Wiesbaden, 1926, p.

дэвшээд, бэйлүүдийг хазаарлаж, засаглалаас шахаж эхэлснээр цолын нэр хүнд доошилж, Чингийн хэргэмд гутгаар зэрэг эзэлсэн тэрхүү зогсоолдоо тулжээ.

Хан, хаан (мо. *qan, qaγan*, ма. *han*, хя. 可汗 *kehan*) Монголын хаан цолын сурвалж манж нарт чухлаар нөлөөлснийг эрдэмтэд маргаангүй хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл, *Сэцэн хүндлэн хан* цол булган сүүлтэй байсан гэж хэлж болно.

Хаан нь гарлын хувьд алтай хэлний үг бөгөөд түрэг-монгол нүүдэлчдэд нийтлэг байж иржээ. Ямар боловч, энэ цол даянд танигдсан нь Чингис хан, түүний залгамжлагчдын үйл хэргээр бүтсэн үнэлэмж.

Уг цолыг монгол, дөрвөлжин бичгийн дурсгалуудад гагцхүү Чингисийг *qan* гэж, Өгөөдэйгөөс Лигдэн хүртэл бүгд *qaγan* гэж бичиж ирсэнтэй холбоотойгоор,¹⁴ *хан (qan)* - *хаан (qaγan)* хоёрын тухай багагүй мэтгэлцэж ирсэн билээ.¹⁵ Хэрэв Ш. Чоймаагийн эдүгээчлэн хэлбэл, Монголын эзэнт гүрний үеийн “*хаан*” бол албан тушаал, *хан* нь Хан хурмаст, Хан уул зэргээр тохиолддог хамгийн эрхэм дээдийг илэрхийлсэн цол гэх үзлийг зөвшөөрвөл,¹⁶ XVI зуунд хан олширсны учрыг ялгаж ойлгоход дөхөмтэй болж ирнэ. Тэдгээрийн эхэнд Түмэдийн Алтан хан (1507-1562) байх ч, бидний авч үзэж буй дээрх хан бус. “*Эрдэнийн товч*”-д өгүүлснээр, тэр бээр баруун түмний жонон байхдаа Дарайсун Гүдэн (1520-1557) хаанаас “*хааны төрийг хашигч шидай хан*” цолыг нэхэмжлэн авсан гэдэг.¹⁷ Сурвалжийн энэхүү мэдээнд итгэвэл, түүний “хан”-ыг “*шидай*

590. Franz Michael 1965, p. 84, n.64; Pamela Crossley, *A Translucent Mirror, History and Identity in Qing Imperial Ideology*, University of California Press, California, 1999, p.163, n.78.

¹³⁾ Олон зохиолд түүнийг бас Абахай хэмээн нэрлэдэг. Гэвч, Стари түүнийг Абахай хэмээх нэрээр манж болон хятад сурвалж огт дурдагддаггүй бөгөөд Оросын нанхиадач Г.В.Горскийн хийсэн алдаа гэж үздэг. Giovanni Stary, *The Manchu Emperor Abahai: Analysis of an Historiographic mistake*, Central Asiatic Journal, 28, 1984, 296-299.

¹⁴⁾ Жишээлбэл, 1224/25 оны “*Чингисийн чулууны бичиг*”-т *Činggis qan*, дараагийнх нь 1257 оны “*Мөнх хааны хөшөөний бичээс*”-т *Möngke qaγan*, 1289 оны Аргунаас Францын Филипп хаанд илгээсэн бичигт *qaqan* гэж бичсэн гэх мэт.

¹⁵⁾ Пол Пеллио (Paul Pelliot) Өгөөдэйг анхны *хаан* цолтон гэдэг. Сонирхолтой нь, Жон Бойл хаан бол нэхэн өргөмжлөх цолын (posthumous title) нэг хэлбэр гэсэн. Тэрбээр, Гүюг хаанаас IV Инносентэд илгээсэн захидал дахь “*Чингис хан ба хаан*” гэсэн хэллэг дээр Пеллиогийн хаан бол Өгөөдэй гэсэн тайлбарыг дагаж, тус албан бичиг Өгөөдэйг нас барснаас хойш 5 жилийн дараа бичигдсэн гэдэгт тулгуурлажээ. John A. Boyle, *On the Titles given in Juvaini to Certain Mongolian Princes*, Harvard Journal of Asiatic Studies, Vol.19, No.1/2 (Jun., 1956), p.152.

¹⁶⁾ Ш. Чоймаа гол үндэслэлээ “*Монголын нууц товчоон*”-ы бичлэгээр гаргасан. Тухайлбал, “МНТ”-ны 220 дугаар зүйлд “Төдий эсгий туургат улсыг шударгатгаж, барс жил Ононы тэргүүнээ хуриж (хурж), есөн хөлт цагаан туг байгуулаад, Чингис хаанаа хан нэр тэнд өгвэй” гэдэг. Мөн одоо хүртэл Хэнтий хан уул, Богд хан уул, Хан гарди, Хан тэнгэр, Хан Хурмаст гэхээс бус хаан гэж хэлж өгүүлдэггүйг сануулсан. Ш. Чоймаа, *Хаадын үндсэн хураангуй алтан товч*, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 5, Соёмбо принтинг, Улаанбаатар, 2006, т. 47, з. 42.

¹⁷⁾ Сагансэцэн, *Эрдэнийн товч*, хөр. М. Баярсайхан, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 8, Соёмбо принтинг, Улаанбаатар, 2006, т. 135. *Шидай* цолын утгыг Ринчингаваа, Хөх-Өндөр нар Хүннүгийн үеийн бага хаадын цол *шю-ту ван*, Сайшаал, Улаан нар хятадын эртний эрхин түшмэл *сы-ту*, Буяндэлгэр Юань улсын Шицзу хаан гэдэг нэрийн авиачилсан хэлбэр гэж, М. Баярсайхан нар “МНТ”-ы *жэу тау* байж болох тухай тус тус таамаглалаа дэвшүүлсэн.

хан”-аас хураамжлагдсан нэршил болно. Халхын ханы анхных болох Түшээт хан бол Гэрсэнзийн гуравдугаар хөвгүүний ахмад хөвгүүн Абтайд III Далай ламаас өгсөн “Очирваанийн хувилгаан Очирт бат Түшээт хан цол”-оос үүдсэн. Удалгүй Гэрсэнзийн тавдугаар хүүгийн ач Шолой (1567-1872) биеэ “Сэцэн хан” хэмээж, Гэрсэнзийн ахмад хүүгийн ач Лайхур бас биеэ хан гэж дуудаад, түүний хөвгүүн Субадай “Засагт хан” болжээ.¹⁸ Үүнийг магадгүй нэг удмын хойчсын тэнцүүрхлийн илэрхийлэл гэмээр байна. Улмаар, хааны угсааны биш ноёд хүртэл, жишээ нь хошуудын Бүүвэй, ойрдын Галдан нар хан цолтой явжээ.¹⁹ Галданы хан цол бас Далай ламаас үүдэлтэй, түүнийг Зүүнгарын хунтайж өргөмжлөгдсөнөөс хоёр жилийн дараа Далай лам олгосон. Нэгэнт Ойрдын удирдагчид хан цол олсон учраас, Галданцэрэний (1727-45) үеэс тогтвортой уламжилсныг “Монголын уг эхийн түүх” зэрэг сурвалж харуулдаг.²⁰ Ингэхлээр, XVI-XVII зууны үеийн хан бол хааны ханаас өөр түвшинд бий болсон, түүний олшрол нь адилтгалаар бүтээгдсэн гэж үзүүштэй. Эндээс нэгтгэвэл, нэгдүгээрт, хан, хаан хоёрыг их багаар харьцуулах шаардлагагүй, хоёрдугаарт, хаан юм уу түүний залгамжлагч, эсвэл бүр удмынх нь хүн мөн бусыг үл харгалзан хан цол зүүснээр, учир шалтгааны үүднээс харшлахгүй буюу тодруулбал, сүүлийн хан нар шүтээн болсон өвөг дээдэстэйгээ эгнэж их зүрх гаргасан гэмд унахгүй, цаашилбал, монгол ноёд Нурхачийг хаан болгосон явдалгүй, ердөө тухайн цагт дэлгэрч байсан эрхэм цолоор хүндлэмдүү элгэмсүү хандлагаа үзүүлсэн хэрэг юм.

1626 онд Нурхачи Хорчины Ууба хунтайжийг Түшээт хан хэмээж, авга ахыг нь Дархан, дүүг Засагт дүүрэн цолоор шагнасан нь манжаас монголын язгууртныг

Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 5, Соёмбо принтинг, Улаанбаатар, 2006, т. 317, з. 729.

Тэрхүү “жэү тау”-г Кливез, Рахевилц нар Сүн улсын үеэс гаралтай, Алтан улсад хэрэглэсэн төвшитгөх түшмэл (招討 zhaotao)-ийн цол гэж тайлбарласан. Ё. Жанчив дөрвөлжин бичгийн дурсгалын баримтаар “жэү тау” гэж унших нь зүйтэйг тэмдэглэсэн. Элдэндэй, Ардажав нарынхаар Хятан, Алтан, Юань улсын ноёдын нэр бөгөөд бууж өгөгсдийг элсэн авах, урвагсдыг дайлан цохих зэрэг үйлийг хамаарна. Юань улсын үед Төвд, Лавран зэрэг газарт жэү-тау түшмэл (ирүүлэн оруулах түшмэл) хэмээн байгуулж байсан ба Даймин улс болохуйаа аймаг нутгийн ноён болсон гэж тайлбарладаг. F. W. Cleaves *The Secret History of the Mongols*, v. I, Cambridge, 1982, p.63; Igor de Rachewiltz, *The Secret History of the Mongols, A Mongolian Epic Chronicle of the Thirteenth century*, Vol.1-2, Leiden-Boston, 2004, pp. 494-95; Ё. Жанчив, *Монголчуудын зарим цол хэргэмийн учир*, Солонгосын балар эртний соёл, гарал үүслийн асуудал, хурлын эмхтгэл, Улаанбаатар, 2008, т. 60-61; Eldendei, Ardajab, *Mongyol-un niyuča tobčiyān, Seyiregьyl tayilburi*, ЦМСККQ, Кцкеqota, 1986, т. 368-369.

¹⁸⁾ Д. Гонгор, *Халх товчоон I*, Улаанбаатар, 1970, т. 48.

¹⁹⁾ А. Очир, *Монголын Ойрадуудын түүхийн товч*, УБ, 1993, т. 85. Ойрдын ноёд хан цолыг тун ховор хэрэглэж байсан хийгээд түүнд Монголынх шиг өв залгамжлах шинж байгаагүй учраас Жүнко Мияваки “Зүүнгарын хаант улс” (Zyngar khanate) гэдэг нэр томьёо төдийлөн зохистой бус болохыг онцлон тэмдэглэдэг. Junko Miyawaki, *Did a Dzungar Khanate really exist?*, Journal of the Anglo-Mongolian Society 10:1-5, 1987; Junko Miyawaki, *On the Oyirad khanship*, D. Sinor (ed.), Aspects of Altaic Civilization: Proceedings of the Thirtieth Meeting of the Permanent International Altaistic Conference, Indiana University, Bloomington, Indiana, June 19-25, 198, p.142-153. Bloomington, Indiana University Press, 1990.

²⁰⁾ Badaï, Altan-Orgil, Erdeni, *Oyirad teьken surbulji bičig*, ЦМСККQ, 1985; На. Сүхбаатар, *Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд*, Улаанбаатар, Соёмбо принтинг, 2001.

өргөмжилсөн явдлын эхлэл байв. Манж нар монголчуудад эргээд хан цолоор нь хариу барьсан явдал хоёр тал цолын эрэмбийн хувьд ч ижил холбоолсныг харуулна.²¹ Удалгүй Мин улс болон Монголд зэрэг шахам тохиолдсон доор өгүүлэх хоёр азгүйтэл нь манж нарт монголчуудын “сэтгэлийн бэлэг”-ийг олон үндэс угсаатныг нэг жолоонд хурааж чадсан Монголын эзэнт гүрний удирдагчийн цол байсантай нь уялдуулан сэтгэж, өөрсдийгөө Өвөр Азийн хааны залгамжлагч болгон зарлах давамгайллыг бүрдүүлж өгчээ. Үүний нэг нь бол Мин улсын хаан манжийн удаа дараагийн довтолгоог амжилттай эсэргүүцэж байсан жанжин Юань Чунхуань (хя. 袁崇煥 Yuan Chonghuan, 1584-1630)-ыг 1630 онд Бээжинд төрд тэрсэлсэн хэргээр баривчлаад, улмаар жанжин бээр нас барсан явдал юм. Нөгөө нь, манж-өвөр монголын хамтын довтолгоонд дийлдсэн монголын хаан Лигдэн өөд болсон явдал болно. Ингээд Мингийн хувьд өөдөө шидсэн чулуу өөр дээр нь унахад, Алтан улсын аманд шар тос оров. Хунтайж эдгээр завшааны огтлолцол дээр 1636 онд улсынхаа нэрийг *Дайчин улс* гэж халаад, цолоо *Агууд өршөөгч найрамдуу богд хан*²² (ма. *ᠶᠣᠰᠢᠨ ᠤ᠋᠋ᠨᠠᠭᠤ ᠠᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠠᠳᠤ ᠠᠨᠨᠠᠭᠤᠳᠤ ᠬᠠᠨ*) болгон тодотгож, *Дээд эрдэмт* хэмээх шинэ он тоолол эхлүүлээ.²³ Харин Монголын хан нар хан цолтойгоо хэвээр, гэхдээ тэдний эрх мэдэл засаг ноёныхтой адил хэмжээнд үлдсэн билээ.

Хуанди (ма. *hūwangdi*, мо. *quwangdi*, хя. 皇帝 huangdi) Өмнө өгүүлсэнчлэн, манж нарт хаан байх нь хангалттай үр өгөөжөө өгсөн гэж харагдаж буй. Тэгтэл, манж нар Цагаан хэрэм давангуут хуанди болсон билээ. Тэдний хаанд ханаагүйн учрыг хятадын ертөнц дэх хуандийн үнэ цэнээр ойлгож болно, үүний тулд хятад уламжлал руу түр зуур хандъя.

Тус цолыг анх Цинь улсын (хя. 秦 Qin ХТӨ 221- 207) Ши хаан хятадын эртний домгийн хаад болох “гурван хуан, таван ди”-ээс үүсгэн бүтээж, хэрэглэснээс хойш Дайчин гүрнийг мөхөх хүртэл улсын эзнийг хэлж байв. Сыма Цяний “Түүхэн тэмдэглэл”-ээр, гурван хуан бол Тэнгэр (хя. 天皇 Tianhuang), Газар (хя. 地皇 Dihuang), Тай (хя. 泰皇 Taihuang); таван ди нь Хуанди буюу Шар хаан (хя. 黃帝 Huangdi), Жүаньшү (хя. 顓頊 Zhuanxu), Кү (хя. 瞽 Ku), Яо (хя. 堯 Yao), Шүнь (хя. 舜 Shun) болно.²⁴ Хятадыг захирах эрх эдгээр хаадаас уламжлахыг “зүй ёсны” гэж үздэг. Энэхүү

²¹⁾ Холбоолох гэдгээр, манж-монголын анхан үеийн харилцаа олон талаар холбоотны шинжтэй байсныг хураасан болно. Энэ үеийн талаар, Elverskog Johan, *Our Great Qing*, University of Hawai'i Press, Honolulu, 2006; Sneath David, *The Headless State*, Aristocratic orders, Kinship society, Misrepresentations of Nomadic Inner Asia, Columbia University Press, New-York, 2007, pp.181-183 зэрэг бүтээл болон эдгээрт бичсэн шүүм өгүүлэл Munkh-Erdene Lhamsuren, *The 1640 Great Code: an Inner Asian parallel to the Treaty of Westphalia*, Central Asian Survey, Vol. 29, No. 3, 2010, pp. 269-288 -ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

²²⁾ Монгол тогтсон орчуулга нь энэ юм. Үгчлэн орчуулбал, *Өршөөл агуу найралт богд хаан* гэнэ.

²³⁾ *Jiu Manzhou dang*, 1969, p. 4587, 4738.

²⁴⁾ Эдгээрт хэнийг багтаах нь сурвалжаасаа хамаарч, 6, 7 хувилбартай. “Түүхэн тэмдэглэлийн нэмэлт” зэрэг хэдэн сурвалжид гурван хуанд бичиг үсэг, загас агнуур, ан гөрөөлөхийг зааж өгсөн Фүси (хя. 伏羲 Fuxi), түүний эхнэр эсвэл эгч юм уу дүүгээр дүрслэгдэж, хүн амьтныг бүтээсэн гэдэг Ньюа (хя. 女媧 Nüwa), газар тариалан, анагаах ухааныг заасан Шэньнун (хя. 神農 Shennong)-г оруулдаг бол, “Хаад вангийн залгамж” (хя. 帝王世系 Diwang shixi) зэрэг

зүй ёсны онолыг Окада Хидэхирогийн тайлбарласнаар авч үзвэл, шалгуур нь үе залгамжлалын зарчим юм.²⁵ Түүний дагуу, хаан ширээ Хуандийн (Шар хаан) удмынханд маргаангүй өвлөгдөхийг дэмжиж, тэр улсын хааныг *тэнгэрийн хүү* (хя. 天子 tianzi) гэдэг.²⁶ Гэтэл хэрэв залгамжлалыг зүй ёсноос өөр замаар, хүч түрэмгийллээр өөр удам угсааныхан олж авсан бол хэрхэн зүй ёс руу шилжүүлэх вэ гэдэг асуудал тулгарна. Ийм тохиолдолд, тухайн хаант төрийн буян буурсан учраас тэнгэр өөрийн бошгыг халж, шинэ төрд өгөх ба үүгээр зүй ёс шинэчлэгдэн эхэлнэ гэж үздэг аж. Жишээлбэл, энгийн тариачин гаралтай Лю Бангийн байгуулсан Хань улс чухам энд түшиглэж зөвтгөгдсөн гэдэг.²⁷

Дээрх хуанди бол зүй ёсны залгамжлагч гэсэн онол дээр суурилбал, газар тариалангийн бүс нутаг, ажиллах хүч, суурин соёл иргэншлийн бүтээгдэхүүний худалдаа арилжаагаараа ямагт соронздож ирсэн хятадад нүүдэлчдийн байгуулсан эзэнт улсын хаад тэнгэрийн бошгоор дөрөөлж байж эзэн суух болж байна. Гэхдээ, хуанди болсон нөхцөл байдал Юань болон Чингийн хувьд нэлээд ялгаатай.

Монголын эзэнт гүрний байдалд үзвэл, Юань улсын анхны хуанди Хубилай буюу Шизү хуанди (хя. 世祖皇帝 Shizu huangdi) байсан. Түүнчлэн Юанийн хаадын тамгыг хятад хэлээр "*хуандийн эрдэнэ*" гэж байсан.²⁸ Тэр байтугай, монгол бичгийн анхны гэгдэж буй дурсгалаас нэг жилийн өмнө гэж он цагийг тогтоосон Чингис хааны Чанчунь бумбад илгээсэн зарлигийн хятад орчуулгын бичээст түүнийг "*хуанди*" хэмээн сийлсэн ажээ.²⁹ Үүнд, хятадын талаас бол монголын хаан эзнийг ханз үсгээр дүйлгэн орчуулсан гэдэг тайлбар өгч болно. Хожмын монгол хаадын хуанди нэр ч ийм зарчмаар

сурвалжид Шар хааныг багтаах нь бий. Хэрэв Шар хааны гурван хуанд багтаасан бол, түүний оронд таван *ди*-д Шаохао (хя. 少昊 Shao hao) гэх мэт өөр хааныг дурддаг ажээ.

Хятадын домог зүйгээр, орчлон ор хоосон байхад хумхаас өндөг бүтэж, түүний доторх арга, билгээс Паньгү хэмээх төрдөг. Паньгү арга, билиг хоёрыг хувааж, тэнгэр, газрыг бүтээсэн бөгөөд тэдний дунд зогсож 18000 жилийн турш холдуулсны эцэст амрахаар хэвтэх зуур түүний эд эрхтнүүдээс нар, сар тэргүүлэн байгаль дэлхийн юмс бүтсэн. Тэнгэр хаан бол Паньгүгийн дараах анхны домгийн хаан, тэнгэр, газар бүтсэний дараагаар 18000 жил амьдарчээ. Залган, Газар хаан 11000 жил хаанчилсан ба түүнийг галын хаан гэдэг. Дараа нь, Тай буюу Хүний хаан бээр ах дүү есүүл нэгдсэн эзэнт улсыг байгуулж 150 үеэрээ 45000 жил захирсан гэдэг. Үүнээс Хятадын 9 муж гаралтай. Sarah Allan, *The shape of the turtle: myth, art, and cosmos in early China*, State University of New York Press, 1991, pp. 55-73.

²⁵⁾ Окада Хидэхиро, *Дэлхийн түүх мэндэлсэн нь*, орч. Наранбаяр, Инжинаш хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012, т. 90-95.

²⁶⁾ Шар хаанаас эхлэлтэй таван хаадыг дамжин Ся улсад (хя. 夏 Xia, ХТӨ 2070 –1600) хүртэл уг зарчим үйлчилжээ. Сяг Шан улс (хя. 商 Shang, ХТӨ 1600-1046), Шанг Жоу (хя. 周 Zhou, ХТӨ 1046–256) улс цэргийн хүчээр унагаж төрөө тогтоосон, гэхдээ тэд болоод дараах Цинь улс (хя. 秦 Qin, ХТӨ 221–206) ч гэсэн Шар хааны хойчис байсан.

²⁷⁾ Окада Хидэхиро 2012, т. 91.

²⁸⁾ F. W. Cleaves, *The Sino-Mongolian inscription of 1240*, Harvard Journal of Asiatic Studies, Vol.23, 1960-1961, p.68.

²⁹⁾ Уг зарлигийн бичээсийг 1251 онд босгосон. Ц. Ганбаатар, П. Дэлгэржаргал, *Чингис хаанаас Чанчунь бумбад илгээсэн харагчин хонин жилийн нэгэн зарлиг*, Studia Historica, Tom. XXXVI, Fasc.6., Улаанбаатар, 2006, т.50, з.6. Үүнийг харгалзаад ч болов, Хубилайн үеэс өмнөх хугацаанд хамаарна.

уламжилсан болов уу. Өөрөөр хэлбэл, нэгэнт бадарсан Их Монгол улсын идэр хүчний нэгээхэн салбараар хятадыг эзлэн авсан монголын их хаадын зүгээс өөрсдийгөө хуанди гэж нэрлэх санаачлага гаргасан гэхэд санаанд авсаар багтахгүй байна.

Харьцуулахад, манж нар хуандийн төлөө тэмүүлсэн. Тухайлбал, "Дусал бинтгүй үсгийн данс" дахь Сэцэн ханы 3-р он, шар могой жилийн 11 сарын 15-нд газар газрын хот фү-д илгээсэн Хунтайжийн бичиг саналыг маань дэмжинэ. Тухайлбал:

"Алтан улсын хан түшмэл, шүсай, цэргийн иргэнд өгүүлэх нь, ...Үе үеэр хүн зарж уулзсу хэмээвээс Тяньжи хаан, Сүнжэнь хаан бас дарлан Алтан улсын хуанди хэмээхийг боль, өөрчлөн хийсэн тамга боль хэмээсэн хойно, би [Хунтайж] мөн уулзахыг хүсэн хуанди хэмээхийг больж хаан хэмээсүү. Та тамга хийж, өгсөн тамгыг зарсуу хэмээвээс бас уулзахгүй тул би засан тэнгэрт хэлж Чаньсангийн замаар цэрэг ирэв... Хаан сайд хэмээх нь иргэнийг тэжээх эцэг эх бус уу. Танай хятадын хаан сайд уулзсуу хэмээвээс болохгүй, дайныг дурлаваас бид эдүгээ дайн ирсэн бөлгөө. Дайн хэмээх нь хялбар үйл үү? Дагасан түшмэл шүсай цэрэг иргэнийг би эрхгүй тэжээмүй. Дагахгүй эсэргүүцэх хүнийг алахгүй аваас болно уу? Тэр миний алах нь бус, танай хааны алах нь болой. Биднийг улс бага, та нар яахин хуанди хэмээвээс, эрт Дай Ляо, Алтан, Дай Юань тэр цөм бага улсаас гарч хуанди болсон болой. Түүнийг та нар юун хуанди хэмээн болиулсан уу? Тэр байтугай чиний Жү тайзү хуушаан хүн байсан бөлгөө. Тэнгэр өршөөж эрхэмлэж хуанди болгожухуй. Нэгэн овгийн хүн хуанди суусаар гүйцэтгэсэн хууль байна уу? Тэнгэр улиран хуандийг эвдэж, бидний хүн болгосон буй. Бидний хүнийг эрхэмлэж хуанди болгожухуй. Тэнгэр ...[үсэг балархай] тэр хүний дур уу? Тэнгэрийн өршөөхөд миний хуанди хэмээснийг хятад чи болиулбаас тэнгэр мэдэх буй за. Миний сүрд дайлахыг мэдэхгүй хүн хүчийг булаан дайлмуй, мэдэхгүй хэмээн хэлэх буй за" хэмээн эсрэг заалджээ.³⁰

Тус бичигт, Алтан улсын хаад Нурхачи, Хунтайж нар Хулун бүлгийн сүүлчийн дайсагнагч улс болох монгол цус нэлээд холилдсон Ехэ аймгийг дэмжсэн учирт цухалдан босож Ехэ 1619 онд,³¹ Ляодунг 1621 онд авснаас хойш, Мингийн сүүлийн хаад Тяньжи (хя. 天启 Tianqi, х. 1605-27), Чүнжэнь (хя. 崇禎 Chongzhen, х. 1627-44) нартай харилцсан бичгээ ямар боловч "Алтан улсын хуанди" хэмээн хаягласнаараа өөрийгөө хятадын үе үеийн хуанди нартай ижил түвшинд дэвшүүлсэн гэж харагдаж байна. Үүнийг урьд нь, "ДБҮД"-нд Мингийн хаадыг хуанди гэсэн мөртөө өөрсдийгөө үргэлж хаан гэж байсан бичлэг, түүнчлэн тэдгээр хуандиг өөрийн ханаас илүү дээр мөр тэтгэж бичдэг байсан байршил зэрэгтэй харьцуулбал, эшлэлд дурдсан явдал хатгалгын шинжтэй гэсэн таамаглалыг дэвшүүлэх боломжтой.

Хариуд нь, Мингийн талаас Алтан улсын хуанди гэх нэрээ боль хэмээснээр бодвол, тэдний бичиг бусдыг үл ойшоогч хятад төвт үзлийг багагүй эгдүүцүүлж чадсан юм уу үнэндээ, зорилгоо биелүүлсэн гэж үзэж болох юм. Уг бичгийг илгээсэн 1629 оны сүүл

³⁰) Jiu Manzhou dang 1969, pp. 2920–24.

³¹) Сонирхуулахад, Ехэгийн тэргүүлэх хунтайж Гинтайш шатаж буй ордныхоо гал дунд үхэхийнхээ өмнө манж нарыг нэг өдөр Ехэгийн нэгэн эмэгтэй мөхөөж өшөөгөө авна гэж харааж байсан гэдэг. Энэ хараалаас болоод Ехэгээс нэг ч татвар эм аваагүй аж. Михайл Франц үүнд таарах боломжтой ганц тайлбараар 1911 онд манж мөхсөний шалтгаан болсон гэж үздэг Ехонала буюу хатан хаан Циси (Cixi, 1835-1908)-г нэрлэжээ. Franz Michael, 1965, pp. 43-44, n.25.

1630 он хүртэл буюу Манжуураас Хятад руу нэвтрэх ганц гарц болох Шаньхайгуанийг гартаа оруулах хүртэл, манж нарт хараахан түрээд орчих хүч байгаагүй. Тэгээд ч хэрэв хангалттай байсан бол, цэргийн эрдмээр ялж байсан тэр цагт Мингийн дургүйцлийн хариуд харилцан тохирч чадвал “хуанди”-ийн байр сууринаасаа “хаан” руу буцаж болох юм гэсэн санаа дээрх бичигт цухалзаж үлдэх байсан гэж үү. Өөрөөр хэлбэл, өгүүлсэн үе Мин улсыг бүрэн эзлээгүйг, бас тэдэнтэй өрсөлдөх санаагаа албан бичгийн хэв маягаар түншиж байсныг илэрхийлнэ. Чухамдаа, ийм өдөөлгийг зөвлөх хангалттай олон хятад соёлд нэвтэрсэн *баги* нар хаанд үйлчилж байсан хийгээд³² манж нар олон соёлын хилийн бүс нутгаар суугчид буюу Фредерик Вэйкман (Frederick Wakeman)-ы нэр томьёогоор “*transfortiersmen*” байсныг харгалзвал,³³ уг үйлдэл ерийн хэрэг баймгүй билээ.

Албан бичгээр нэхэмжлээд олдоогүй энэхүү цолд хүрэх амаргүй замыг Хунтайж эхлүүлсэн. Тэр бээр монгол тал руу холбоотнуудаа зузаалж, Солонгосыг эзлэн, зүүн жигүүрээ бататгаад, сая хятад руу ухралгүй чиглэх боломжтой болсон ч, зорьсондоо хүрч чадалгүй 1643 онд нас барав. Гэвч төр баригч Доргон түүний үйл хэргийг үргэлжлүүлж, ганцхан жилийн дараа бяцхан хааныг Бээжинд хаан өргөмжилжээ. Ингэснээр, уг цолын төлөөх эрмэлзэл Эеэр засагчийн үеэс эсэргүүцэлгүй биеллээ олж, хааны зарлиг тэргүүтэн албан бичиг хойшид *Дайчин улсын хуанди* (ма. *Daičing gurun-i huwangdi*) нэрээр уламжилсан байна. Түүнийг залгамжлагчдын хувьд, тэнгэрийн бошгын халааг улам батжуулах үүрэг ноогдсон бөгөөд түүний тул нэн хичээл зүтгэл гаргасныг ялангуяа Тэнгэрийн тэтгэсний хаанчлалын үе толь мэт тодхон харуулдаг.³⁴

Дээр өгүүлснийг дүгнэхэд, Дайчин улс монголын хан цолыг үлдээсний учрыг хамгийн багадаа гурван шалтгааны нэгдлээр тайлбарлах боломжтой гэж харагдаж байна. Нэгд, монголчуудыг язгуурын ёсоор захирах бодлого эргэлзээгүй хамаатай. Нөгөө талаас, дээр авч үзсэн хан цолын утгын хувьслын нөлөөг бодолцох хэрэгтэй болов уу. Үүнд нэмж хэлэхэд, ханы үнэлэмжийн бууралд ханы эрх мэдлийг засаг ноёнтон ижил болгон багасгасан арга хэмжээ багтана. Эцэст нь, эдгээрийн дээр хаан ширээ залгамжлалын тухай үзэл суртлын онцгой байр суурийг харгалзвал зохино. Хэрэв манж нар тэнгэрийн хөвгүүн-хуандийн суурийг нэгэнт эзэлчихсэн байгаагүй бол, монголчуудыг *хунтайж* цол эзэмших эрхгүй болгосонтойгоо адил хан цолыг хураах байсан биз ээ. Ийм өнцгөөс авч үзвэл, тэдний нэг тэнгэрийн доор хоёр хаан/хан байхыг зөвшөөрсөн бодол санааг ойлгож болно. Өөрөөр хэлбэл, тэр цагт нэг л хуанди асан.

Хуандийн гэр бүлийн цол

Хуандийг дагалдан хятад, үр хүүхдүүдийнх нь цол ч бүхэлдээ хятадаас үлгэрлэж, амьдарч ахуй үеийн хийгээд нас барсны дараа нэхэн өргөмжилсөн гэсэн ялгамжтайгаа өвлөгдсөн билээ. Үүнтэй холбогдуулан, манж нар бэйлээс хуандид хүрэх оргилд монголчуудын тавьсан их тэргүүрээр³⁵ замнасан юм бол түүний салшгүй нэгэн хэсэг

³²⁾ Жишээ нь Дахай багш хятад бичгийн соёлд нэвтэрхий нэгэн байсан. Arthur Hummel 1964, pp. 213-214; *Jiu Manzhou dang* 1969, pp. 3828-3830, 4643.

³³⁾ Peter Perdue, *China Marches West, The Qing conquest of Central Eurasia*, The Belknap Press of Harvard University Press, Cambridge, Massachusetts London, 2005, p.111.

³⁴⁾ Энэ талаарх нарийвчилсан судалгаанд юун түрүүн Pamela Crossley 1999-ийг үзнэ үү.

³⁵⁾ Дундад үеийн монгол хэлнээ тэрэг явдаг өргөн их замыг тэргүүр хэмээж байв. Жишээлбэл, “МНТ”-ы §121-д Хорчи Тэмүжиний улсын эзэн болох бэлгийг “Мухлар ухаа үхэр их гэрлүгэ

болох гэр бүлийнхний нь цолд адилтгахуйц нөлөө байсан эсэх, байсан бол хэдий хэр нөлөөлснийг тодруулах явдал чухал юм. Учир нь, ийнхүү үлгэрлэсэн соёлынх нь нэг хийгээд зарим судалгаанд ямар нэгэн хэмжээгээр дутагдаж байдаг монголтой холбогдох сэтгэлийг илүүтэй өргөж, цуваа цагийн үүднээс харснаар, цол хэргэмийн хятад багийн цаанах манжийг ойлгоход тусална гэж бодож байна.

Хятадын уламжлалаар, Дайчин гүрний хуандийн хаан эцэг (ма. han ama) нь *Тай шан хуанди* (хя. 太上皇帝 Tai shang huangdi, то. *Тайхуанди*) болсон, гэхдээ уг цол гагцхүү хуанди эцэг нь хүүгийнхээ хаанчлалын үед саруул тунгалаг тохиолдолд хэрэглэгдэнэ.³⁶ Харин насан хутаг оршсон эцэг хийгээд түүнээс дээших өвөг хуанди нарыг тус бүрийн нэхэн өргөмжилсөн нэрээр алдаршуулдаг. Жишээлбэл, улсыг анх тунхагласан гавьяагаараа Нурхачи *Тайзү* (хя. 太祖 Taizu) хэмээгдэж, үйл хэргийг нь дэвжээсэн Хунтайж *Тайзун* (хя. 太宗 Taizong) гэж нэрлэгдэх зэргээр дараалдаг. Үүний сурвалж хэдий хятадаас гаралтай боловч зөвхөн тэдний ертөнцөд хүчин төгөлдөр зүйл байсангүй, хятадыг эзэгнэсэн бусад төрийн хувьд туулдаг л жам байдгийг Юань улс үлгэрлэн үзүүлсэн бэлэн түүх байсан. Ингэхлээр, хааны эцэг өвгөдийн ийм хүндэтгэлийг хааны дэвшил шигээр хятадтай холбосон шулуун шугамд бус, Өвөр ази руу салаалсан хэлбэрээр өргөн цараатай хүлээн авах нөхцөл байсан, манж нар ч түүнийг ашигтайгаар эзэмшиж чаджээ.

Хааны дараах үе буюу хөвгүүдийн хувьд, тэднийг ураг садны бусад гиоро үрсээс ялгахын тулд 1636 оноос эхлэн *агь* (ма. age) гэж, дуудахдаа уг нэрийн ард *тэр агь* гэж тодотгохыг хуульчлав.³⁷ Үүгээр хуучин ах гэсэн утгатай байсан *агь* нь хааны угсаанд хэрэглэгдэх тусгай үг болсон. Хожим энэ үг монгол хэлнээ *ноёны агь* гэх мэт ихэс язгууртны хүүг илтгэсэн утгатайгаар орж иржээ. Шалтгаан нь, хоёр улсын харилцааны явцад монголчуудаас зүйрлэсэн байдлаар нэвтэрсэн байж болох ч, эрхшээгчийн хувиар манжийн хаант төрийн үзэл суртал үүнийг чанд хориглосон зүйлийг одоогоор хараахан олж үзсэнгүй. Хэрэв тэднийг хүлцсэн гэж үзвэл, учрыг наанадаж доорх хоёр санаагаар ухаж болох юм. Нэг талаар, магадгүй олон агь байсан, түүнчлэн тэдний дундаас хаан ор залгамжлах нэгэн нь *хунтайж* цолоор ялгарах учраас *агь* нэрийн хэрэглээг төдийлөн хязгаарлаагүй байж болно. Нөгөө талаас, бусад үндэстнийг соёлжуулж байгаагаа таашаалтайяа мэдэгдэж байсан тэдний хувьд³⁸ өөрсдийнх нь хэлнээс бусад улсын

(гэр тэргийн шалыг тулах тулгуур багана)-г дээр өргөж, хөлж зүтгэж, Тэмүжиний хойноос их тэргүүрээр мөөрөн мөөрөн айсахдаа Тэнгэр газар эетэлдэж, Тэмүжинийг улсын эзэн болтугай хэмээн улс тээж авч айсуй хэмээн заарид (заарин нар) нүдэнд үзүүлж, надад заамуй" хэмээн өгүүлдэг. Ш. Чоймаа, *Монголын нууц товчоон*, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 1-р боть, 2006, 68-р тал.

³⁶) H.S. Brunnert, W. V. Hagelstrom, *Present day Political Organization of China*, trans. by A. Beltchenko, E. E. Moran, Fuuchow, 1911, p. 2. Тус зохиол нь манжийн улс төрийн байгууллагууд, тэдгээрийн албан тушаал, цол хэргэмийн сайн лавлахын тоонд зүй ёсоор тооцогддог.

³⁷) *Jiu Manzhou dang*, 1969, p. 4125-26. Хааны хөвгүүдийн боловсрол, алба тушаал, амьдралын талаар Evelyn Rawski 1998, pp.117-126-д үзнэ үү.

³⁸) Mark C. Elliot, Ning Chia, *The Qing Hunt in Mulan*, New Qing Imperial History, 2003, pp. 78-ийг харьцуулна уу.

хэлэнд нөлөөлөх явдлыг тэрхүү соёлын түгэн дэлгэрэлтэй холбон ивээсэн гэх боломжтой санагдаж байна.

Хааны гэр бүлийнхний цолын тухай асуудлыг, түүний нөгөө нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох хааны ойр тойрны эмэгтэйчүүдийнхнийг алгасан дүгнэхэд мэдээжээр эртэднэ. Тоо, зэрэглэлээр нь харьцуулахад, хааны эх, эмэг эх, хатан, охидод олгох цол эрчүүдийнхээс илүү олон. Эдгээрээс ихэнх нь мэдээжээр хаан олон эхнэртэй байдагтай холбоотой.³⁹ Тэд шинэ улс байгуулагдсанаас хойш хятад уламжлалаас нэвтрүүлсэн тогтолцооны дагуу найман зэргээр ялгарсан. Түүнээс өмнөх үед харин өөр зураг – "хятад бус уламжлал" харагддагийг үзвэл,

Үжин (ма. *fujin*, мо. *ujin*, *ujin*, хя. 夫人 *furen*). 1636 оноос өмнө Нурхачи болон Хунтайжийн хатад монголтой адилаар *үжин* хэмээгдэж байв. Памела Кросслийн гярхай ажиглаж тэмдэглэсэнчлэн, *үжин* гэж манж, монгол язгууртнуудын эхнэрийг хэлдэг бол, *сарган* (ма. *sargan*, мөн эхнэр гэсэн утгатай) гэдэг үгээр үе залгамжлах зэрэггүй хятад түшмэдийн эхнэрийг ялган нэрлэж байсан.⁴⁰ Үгийн гарлын талаас, Сайшаал, Ш. Гаадамба нарын зарим эрдэмтдийн Алтай язгуурын үг гэх таамаглал буй ч⁴¹ Рашид ал динаас үүдэлтэй хятад хэлний *гэргий* хэмээх үг гэдэг нэлээд бөх оршсон тайлбартай уялдуулахад бодууштай зүйл төрж байна. Юу гэвэл, XVI, XVII зуунд яагаад манж, монголд хятадын *үжин* хамаатай мөртөө, манж түнгүс гаралтай *сарган* нь эсрэгээр хятдыг ялгасан нэршил болчихсон байх вэ? Түүхийн талаас, үжний уг гарал эртний хятадас улбаатай бөгөөд ХТӨ II зууны дундуур мэдэгдсэн хятадын *Жоу улсын судар* (хя. 周礼 *Zhouli*)-г тэмдэглэснээр, *үжин* хааны хатдын эрэмбэд хуанхугийн дараа ордог байжээ. Монголын хувьд, XIII зуун гэхэд үжин нэр хэдийн идээшсэн байсан гэж хэлэхэд эргэлзэх зүйлгүйг “Монголын нууц товчоон” дахь Өгэлүн үжин тэргүүтэн хэн бүхний сайн мэдэх жишээнүүд баталдаг. Эндэх бичигдсэн сурвалжийн хоорондох арав

³⁹ Дайчин улсын хаадын гэрлэлтийн хэв маягийг цуваа цагийн үүднээс нэг гэж авч үздэггүй. Жишээлбэл, 1636 оноос өмнөх үе *олон эхнэрт ёс* (polygynie)-ыг илүү үзүүлдэг бол, хойшлох тусам энэ нь хааны хатад ижил бус байр суурьтай байсан гэх мэт шинжээрээ ялгаатай болж ирдэг. Evelyn Rawski, 1998, p. 128, 132. (Олон эхнэрт ёс гэдэг нэр томъёог С. Дуламын орчуулгаас авлаа. Жан Копан, *Угсаатан судлал, хүн судлалын удиртгал*, орчуулсан С. Дулам, УБ 2007, 57-63-р талд үзнэ үү.) Жинхэнэ олон эхнэрт ёсны тухай ойлголтыг Женнифер Холмгрений үзүүлсэн Хятаны удирдагчдын туршлагаар ойлгож болно. Jennifer Holmgren, *Marriage Kinship and Succession under the Ch'i-tan Rulers of the Liao Dynasty*, TP 72, 1986, p. 44-91. Манжийн түүхэнд үнэтэй үүрэг гүйцэтгэсэн ураг төрлийн барилдлагын дотор гэрлэлтийн өөр хэлбэрүүд ч байдаг. Жишээ нь, төр баригч Доргоныг өөрийн ач буюу Хунтайжийн ууган хүү Хоогэ (ма. Hooge)-ийн эхнэрийг авсан гэж, бас зарим нь Доргоныг Хунтайжийн гэргий Бумбудай буюу Эеэр засагчийн эхтэй гэрлэсэн гэлцдэг. Тиймээс, түүнийг нас барсны дараа цолыг нь хурааж, хүүрийг нь зэрэмдэглэсэн Эеэр засагчийн үйлдлийг гэрлэлтийн левират хэв маягтай (levirate) хамаатай гэдэг ч баттай нотлогдоогүй. Хюммел нар үүнийг цуу яриа гэж үзэхдээ Хоогэгийн эхнэрийн явдалтай хутгасан гэж тайлбарладаг. Arthur Hummel et al, 1964, 300-301-р тал.

⁴⁰ Pamela Crossley 1999, p. 178, n.3.

⁴¹ Ш.Гаадамба монгол манжийн эртний толгойлогч, том биет, баатарлаг анчин бүсгүйн “пудин”, “бодан” гэх мэт нэрийг хувирч утгаараа фүжэньтэй дүйсэн байж магадгүй гэжээ. Гончигжав, *Сүвд эрх хэмээгдэх шастир оршив*, хөр. С. Амарбаяр, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 18, Улаанбаатар, 2006, т.100-101, з.52.

гаруй зуун бол ван, ноён гэх мэт хятад гаралтай бусад нэр цол шигээ үжин цол Цагаан хэрмийн хойд руу нэвтрэхэд хангалттай хугацаа төдийгүй, орохдоо бүр ч эрт орсныг хоёр хэлэн дэх хэлбэр нь гэрчилнэ. Хэлшинжлэлийн үүднээс, манж, монгол хэлний *фүжин-үжин* үгийн эхний гийгүүлэгчээрээ ялгаатай, ингэж ижил байр дахь уруулын гийгүүлэгч монгол хэлэнд гээгддэг мөртөө манж хэлэнд хадгалагддаг явдал бол түгээмэл зүй тогтол. Тус хэлний хувьсал эртний хэв шинжид хамаардаг. Ийнхүү хэлний болон түүхэн баримтаар үзэхүл, нэлээд эртнээс хэрэглэгдсэн цол бөгөөд хятад хэлнээс манж, монгол хоёр хэлэнд их эрт цагт оржээ. Цаашилбал, XVI зууны сүүл, XVII зуун эхэн үеэр Жян Сяншүний бичсэнээр, Нурхачийн таван монгол эхнэр *үжин* цолтой асныг⁴² анхаарах хэрэгтэй. Тэгэхлээр, манжийн монголтой нягт холбогддог олон зүйлийн нэг болох цолын дотор *үжин* багтана гэсэн үг. Өгүүлсэн бүхэнд дөрөөлж хэлэх санаа маань, манжийн үжин бол хятадын гэхээсээ монголын жишээ шигээр аль эрт харь бус болсон, жаахан хэтрүүлбэл манж цолоос өөрцгүй, тийм ч учраас хааныхаа хатныг ийн нэрлэсээр ирсэн.

Гэвч, цаг эргэхэд түүний ийм эрхэм байр суурь тогтож үлдсэнгүй, хожмын сурвалжуудад харагддагчлан хааны түвшнээс бууж, улмаар чин вангаас бэйс хүртэл хэргэмтний гэргий нарыг нэрлэх боллоо.⁴³ Шинэ улсын тунхаглал нь түүний орыг эхлээд *фэй*, дараа нь *хуанху* цолоор сольсон аж.

Фэй (ма. фэй, мо. beuyi/ begiji, хя. 妃 fei). Үжнийг залгасан фэй монголд ч, манжид ч шинж чанарын ялгаатай байсан. Тухайлан, 1644 оноос өмнөх манжийн фэй дээр авч үзвэл, *Айсин гиорогийн уг гарал* (хя. 愛新覺羅宗譜 Aixin jueluo zongpu), *Дайчин улсын хас дэвтэр* (хя. 大清玉牒 Da Qing yudie) зэрэг дахин бичигдсэн түүхэн тэмдэглэлд Хунтайж хэдийгээр өөрийн эхийг *хуанху* хэмээн нэхэн өргөсөн байдаг авч, Нурхачийн бусад эхнэр найман зэргийн тогтолцоонд ороогүй байсан. Тодруулбал, Нурхачийн ууган хүү Чүенгийн эх Хахана жачин *юаньфэй* (хя. 元妃 yuanfei, *аваал фэй*), Мангулдай, Дэгэлэй нарын эх *жифэй* (хя. 繼妃 jifei, *дэд фэй*), Нурхачийн 16 эхнэрээс 4 нь *цэфэй* (хя. 側妃 cefei, *жигүүрийн фэй*), 6 нь *шүфэй* (хя. 庶妃 shufei, *бага/татвар фэй*) байв.⁴⁴ Эдгээр нэрлэлт тэр үеийнхээ дэс, цэрэг-иргэний зохион байгуулалтыг тусгаснаараа манж төрхийг илүү агуулсан байдалтай харагддаг.

Эвелин Равски Дайчин улсын гэрлэлтийн бодлого өмнөх байлдан дагуулагчдынхыг санагдуулдаг боловч толины тусгал мэт хуулбарлаж аваагүй ба эзэлж авсан Мингийн иргэдтэй гэрлэхийг хориглох мөртөө Өвөр азийн тэргүүлэгчидтэй бол хөхүүлж байсныг тэмдэглэсэн.⁴⁵ Тэгвэл, энэ бодлогод монголд идээшсэн хятадас ормол цолын хэрэглээ ямар нэгэн хэмжээгээр эерэг орчин бүрдүүлж өгч байсан гэж үзэх боломжийг дэвшүүлмээр байна. Монголд *фэй* хэдийн танил, Юань улсаас хойш хэрэглэгдэж, монгол түүхэн сурвалжуудад *бэйж* гэх монголжуу хэлбэрээр буй. Гэхдээ, хятадынх шиг хааны сул хатан гэсэн утгатай бус, харин хааны угсааныхныг оролцуулан тайж язгууртны гэргийг хэлж байв. Үүнийг, жишээ нь Умард Юанийн хоёрдугаар үеийн хаан Усхал хааны хүү Харгучаг дүүрэн хунтайж (1363-1399)-ийн эхнэр Өлзийт гоо хун бэйж болон Баянмөнх жонон (1452-1476)-ийн эх, Харгучуг тайжийн гэргий Сэцэг бэйж

⁴² Evelyn Rawski 1998, p.340, n.18.

⁴³ Жишээ нь, Daijing gurun-i uheri qooli, 60-р дэвтрээс үзэж болно.

⁴⁴ Evelyn Rawski 1998, p.132.

⁴⁵ Evelyn Rawski 1998, p.128.

нараар нотолж болох юм. Тийм ч учраас, Ван ши жи (1551-1618) "*Сань Юнь бичиг, харь үгийн тайлбар*"-таа тайжийн эхнэрийг хэлнэ, хааны фэй шиг гэж ийм утгыг онцолсон биз ээ.⁴⁶ Ташрамдуулан, ялангуяа Өлзийт хатны "*хун гоо бэйж*" цолын тайлбар эцсийнх байж чадах уу гэдэг эргэлзээ төрснийг тэмдэглэе. Бид уг нь Монголын түүхэн сурвалжийн цувралынхаа тайлбарт, хятад хэлний хунтайж хэмээхийн *хун* [хя. huang], *гоо* нь Алун гоо, Түмэлүн гоо зэргээр хатдыг өргөн хүндэтгэж асан эртний монголын уламжлалт чимэг тодотгол, *бэйж* цолтой хатдаас хунтайжийн хатныг *хун бэйж* хэмээн ялгаж байсан бололтой гэсэн буй.⁴⁷ Гэтэл яагаад хятдаас ормол цолын дундуур монгол үг орж ирсэн байх вэ? Нягтлахын тулд, бусад монгол сурвалж дахь бичлэгийг үзвэл, *Лу. Алтан товч, Хураангуй Алтан товч, Шар тууж* зэрэгт дээрх мэтээр Өлзийт *гоо хун бэйж* гэдэг бол "*Эрдэнийн товч*"-д Өлзийт *хун гоо бэйж* гэсэн ба мо. *юи-а* гэж бичсэн байдаг. Ийм чөлөөтэй сэлгэдэг байдал асуудлыг лавшруулахаас бус, шууд шийдэхгүй. Үүнээс улбаалан, ормол цол гэдгээр нь хандаж, эх сурвалж руу нь буюу эртний хятдын улсуудаас Тан улс, улмаар тэнд төвлөсөн Юань улс, Дайчин улсын төгсгөл хүртэл өргөжин уламжилсан цол руу мөшгөхөд, *хуанфэй* (монголжсон дуудлагаар *хунбэйж*) гэж байхгүй, харин *хуангүйфэй, гүйфэй, фэй* бий. Эндээс, Өлзийтийн тус цолыг *хуангүйфэй* (хя. 皇貴妃 huang guifei)-н монголжсон дуудлага гэж таамаглаж байна. Монгол бичгийн бичлэг таамаглалыг маань ямар нэг хэмжээгээр үгүйсгэж болох ч, өөр талаас, хятад хэлний *gui* задгай үет үгийг монголчууд өөрийнхөө хэлний "*гоо*"-той адилтган ухсан байж болно, магадгүй тэгээд *хун гоо бэйж - гоо хун бэйж* гэж чөлөөтэй сэлгэдэг. Нэмж хэлэхэд, ормол цолын гарлын тухай монгол сурвалж доторх тайлбар болох Рашпунцагийн "*Болор эрих*"-д зөвхөн *фэйн* тухай бий.⁴⁸ Мэдээж, үүнд гайхах зүйлгүй буюу тэнд бүгдийг багтаах зорилго ч байгаагүй, ердөө тохиолдсон дээр нь дөрөв, таван цолын монголжсон дуудлагыг бичээд өнгөрсөн тул тухайн цагт хуангүйфэй байгаагүй гэсэн баталгаа болохгүй.

Энэ бүхнээс үндэслэвэл, Юанийн үеэс монголд нэвтэрсэн цолын дотор хатдын эрэмбэт цолууд багтаж байсан гэж хэлэх байна. Улмаар, манжийн эхэн үеийн фэй дээр ирэхэд, ялангуяа монголтой ураг төрлөөр сүлбээлсэн тэр цагт, фэй өргөмжлөгдсөн Нурхачийн гэргийдэд уг цол дасаагүй шинэ зүйл бус, өөрөөр хэлбэл, монгол, хятад, манж аль ч соёлын хөрснөөс нийтлэг байсан. Тийм учраас, цаашдаа хятадаас үлгэрлэсэн зэргийн тогтолцоонд шилжих завсрын үе шатад таатай суурь болж өгчээ.

Хуанху (ма. huwangheu, хя. 皇后 Huanghou). Фэйгийн дэсийг залган гарсан Дайчин улсын хатдын найман зэргийн тогтолцоонд *их хатан* буюу хуанху тэргүүлэх байрыг

⁴⁶) Henry Serryus, *Two remarkable women in Mongolia: The Third Lady Erketi qatun and Dayičing-beyiji*, Asia Major, Vol. XIX, 1974, 194, n.15. Бас Ulaan, *Erdeni-yin tobči-yin sudulul*, orči. Altanbaγan-a, БКQ, Liyooning, 2005, т. 444-д үзнэ үү. Ван ши жигийн *bizhi* хэмээн тэмдэглэснийг Л. Лигети "bigi, begi"-тэй холбодог, Х. Серрюс begi+ji (эм хүйсийн дагавар) гэж үздэг. L. Ligeti, *Deux tablettes de T'ai-tsoung des Ts'ing*, Acta Orientalia...Hungarica. 8, 3, 1958, p. 227; H. Serruys, *Four Documents relating to the Sino-Mongol Peace of 1570-1571*, Monumenta Serica 19, 1960, p. 5.

⁴⁷) Сагансэцэн, *Эрдэнийн товч*, хөр. М. Баярсайхан, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 8, Соёмбо принтинг, Улаанбаатар, 2006, т. 298, з. 615.

⁴⁸) Рашпунцаг, *Болор эрих*, хөр. М. Баярсайхан нар, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 14, Улаанбаатар, 2006, т.528.

эзэлнэ. Улсад нэг хуанху байх бөгөөд⁴⁹ Улсын эх (хя. 国母 guomu) гэсэн хүндэтгэлийн цолтойгоор гол ордонд (хя. 中宫 Zhong gong) заларч асан. Хуанхугаас дээших цолд, хаан тэнгэр болсны хойно луугийн ширээнд суусан шинэ хааны хатан эхийг өргөмжлөх **Хуантайху** (ма. huwang taiheu, хя. 皇太后 Huang taihou), эмэг буюу их хатан эхийн **Тай хуан тайху** (ма. tai huwang taiheu, хя. 太皇太后 Tai huang taihou) цол байх бол доош дараах маягаар эрэмбэлэгдэнэ. Үүнд, бага хатад гэж дүйлгэж болох нэг **хуан гүйфэй** (ма. huwang guifei, хя. 皇贵妃 huang guifei), хоёр **гүйфэй** (ма. guifei, хя. 贵妃 guifei), дөрвөн **фэй** (ма. fei, хя. 妃 fei) байх ба түүнээс доош татварууд нь зургаан **пинь** (ма. pin, хя. 嫔 pin), тооны хязгааргүй **гүйрэн** (ма. guiren, хя. 贵人 guiren) буй. Тус зургаан дэсийн доор **чанзай** (хя. 常在 chang zai), **да ин** (хя. 答应 da ying) байдаг.

Хааны охидын цолын хувьд, Нурхачийн үед **гэг** (ма. gege) гэдэг байснаа 1636 онд Хунтайж тэднийг хатнаас төрсөн бол чин вантай дүйцэх эрэмбэ бүхий **улсын гүнж** (ма. gurun-i gungju < хя. 公主 gongzhu), бага хатдаас төрсөн бол жүн вангийн энтэй **хошой гүнж** (ма. hošoi gungju) хэмээх болгосон.⁵⁰ Ийм дүрэм журам гарал угсаанаас шууд хамааралтай, тиймээс угтаа насан турш мөрдөгдөхүйц байлтай. Гэвч, энэ нь манжийн түүхэнд хэзээд зөрчигдөөгүй гэсэн үг бус. Тухайлбал, Тэнгэрийн тэтгэсэн өөрийн ихэд ойшоодог хайртай хошой гүнж Хэсяо (Heshiao, 1775-1823)-г улсын гүнж болгон дотнолсон.⁵¹ Энэ хэдий хааны хувийн үнэлэмж төр ёсонд нөлөөлснийг илэрхийлсэн нэгэн тохиолдол боловч хэрэв илүү өргөн агуулгаар Эсэр засагч хаан хайртай хатнаа асар түргэн хугацаанд зэрэг дэвшүүлж байсан зэрэг бусад хаадын иймэрхүү хандлагыг оролцуулан үзвэл, тэдний хөрвөх сэтгэлгээний онцлогийг харуулсан нэгэн жишээ болж чадах юм.

⁴⁹ Бруннерт нар хэрэв хоёр хатан ахул **гол** ба **баруун ордны** (хя. 西宫 Xi gong) гэж байршлаараа ялгарна гэж тэмдэглэсэн. Brunnert 1911, p. 2. Миний бодлоор, энэ магадгүй манжийн эхэн үеийн тухай өгүүлсэн хэрэг болов уу. Хунтайжийн үед хоёр үжин дээрээ нэмж, 1631 онд Жарудын Дайчин бэйлийн охиныг **зүүн ордны** (хя. 东宫 dong gong) үжин болгож авсан. Сурвалжид тэмдэглэснээр, тэр бээр үүнийг эхнэрт дуртайгаар авсан бус, урьд дундадын болон баруун үжин байж, зүүн нь байгаагүй учраас “төрийг санаж гурван хатныг бүрдүүлсүү” гэж авсан хэмээжээ. Liu Manzhou dang, 1969, pp. 3704-3705. Түүний “**ёс бүрдсэн**” хэмээснийг манжийн талаас жигүүрийн зохион байгуулалтын дүрэмд, нөгөө талаар ордны дүрэмд аль альд нийцсэн явдал байсан гэж хэлж болох юм.

⁵⁰ “Гүнж” харин монголд хожуухан орж ирсэн гэж хэлж болно. “МНТ”-ы баримтаар, Чингис хааны охид бэхи цолтой байсан, Жүрчидийн Алтан хан Чингис хаанд “Гүнжү” нэртэй охиныг гаргаж өгсөн гэж гүнжийг хүний нэр гэж ойлгосон бичлэг (“МНТ” §248) хоёрт үндэслэвэл, XIII зуунд монгол хэлэнд энэ үг төдийлөн танил байгаагүй аж. Тэгэхлээр, гүнж монголд танигдсан нь лав Юань улсын үеэс хойш хугацна. Ш. Чоймаа, *Монголын нууц товчоон*, 2006, т.196.

⁵¹ Тэнгэрийн тэтгэсэн хаан Хэсяо гүнжийг өөрийн ихэд ивээдэг түшмэлийн хүү болох Хэшэнь (хя. 和珅 Heshen, уг нэр нь Фэншэнь Иньдэ)-д өгсөн. Хэшэнь хожим 1806-1810 онд Улиастайд цэргийн жанжнаар томилогдон ирж байв.

Хааны гэр бүлийн эмэгтэйчүүд зэргийнхээ дагуу хувцас хэрэглэл, хоол хүнс, шан харамж, шивэгчнээс авахуулаад эрх ямбаараа ялгарна.⁵² Жишээлбэл, хатдаас чанзай, даин нар хууль, гадаад харилцаа гэх мэт албан бичгийн зүйлд барагтаа үзэгдэхгүй бол эхний зургаан эрэмбийн хатдыг бичигт тэмдэглэхдээ хүртэл тогтсон байршилтай, хуанхуг хамгийн дээрээс мөр тэтгэж, бусдыг доош зэргээр нь буулгасан байдалтай бичдэг. Манжийн язгууртан эмэгтэйчүүд хэдий хятад цолтой болсон боловч хятдуудаас өөрөөр буюу өөрсдийн уламжлалаар илүү эрх чөлөөтэй, эрх мэдэлтэй амьдарч байжээ. Тал талын баримтуудаас үзэхэд, тэдэнд хятад эмэгтэйчүүд шиг хөлөө боохгүй байх эрх зарлигаар олгогдсон ба олны газар явж, морь унах, харвах намнахад боловсорч, анд гөрөөлөх, тэр байтугай дайнд оролцож, бөөгийн зан үйлийг ч гүйцэтгэж байсан.⁵³ Үүний нэгэн жишээ бол эр хүний эрдмийг гаргууд эзэмшсэнээрээ цолгорсон Хэсяо гүнж бөгөөд үнэн эсэхийг үл мэдэх ч хаан хэрвээ түүнийг хүү байсан бол залгамжлагчаа болгох байсан гэж хэлсэн.⁵⁴ Түүнчлэн Женнифер Холмгрений харьцуулан гаргасан Хан хятад болоод Хан бус хаадын ураг төрлийн барилдлагын онцлог, Эвелин Равскийн нухацтай үзүүлсэн манжийн язгууртан эмэгтэйчүүдийн амьдралын хэв маяг зэргээс ажиглахад⁵⁵ 1636 оноос хойших хатдын зэргийн асуудал Мингийн тогтолцоог санагдуулдаг мөртөө Минтэй адилгүй нь хатнаас төрсөн хөвгүүдийн залгамжлалын асуудлыг хязгаарладаггүй. Үүний цаана хатдын нэр хүнд хааны тааллыг хүртэх, хөвгүүн төрүүлэх гэх мэт төрд онцгой үүрэг гүйцэтгэснээр өсөх юм уу эсрэгээр буурах зэрэг шалтгааны улмаас зэрэг нэмэгдэх, хасагдах шилжилтийн утга агуулагдаж буй. Тэр бүхэн навчит өргөмжлөл (ма. *abdangya fungnehen*, 尙; хя. 册) хэмээх өргөмжлөл, тусгай ёслол, зүйлээр баталгаажиж байсан.⁵⁶ Эдгээрт тулгуурлал, зэргийн тогтолцоонд шууд хятаджил гэхээсээ илүү холимог шинж чанар тодорч байна.

Эцэст нь нэгтгэн дүгнэхэд, манжийн бэйл, үжний хамтаар дэвшсээр Дайчин улсын хуанди, хуанху хэмээх өндөр их сууринаа хүрчээ. Хэрэв хуандийн гэр бүлийн цолыг тэдний зүүсэн баг - өнгөн дүр гэж төсөөлбөл, тэр нь хятад нэршилтэй болохоор хятад хийцтэй мэт боловч тэрхүү багийн цаанах нийгмийн байр суурь, хангамж, эрх зэргийг багтаасан мөн чанараараа жинхэнэ хан хятадынхаас ялгаатай болох нь илэрхий аж. Улмаар, монгол талын хэлхээг онцлон авч үзсэндээ үндэслэн, тэр багийн хийц маяг, хэлбэр дүр нь хүртэл дан нэг эдээс бүтсэн бус, харин монгол, манж махбодыг багагүй

⁵²) Evelyn Rawski, *Qing Imperial Marriage and Problems of Rulership*, Marriage and Inequality in Chinese Society, ed. Rubie S. Watson, Patricia B. Ebrey, Berkeley 1991, pp. 191-93.

⁵³) Жишээ нь дараах зохиолуудыг үзэж болно. Үүнд, Elliot Mark C., *The Manchu Way*, The Eight Banners and Ethnic Identity in Late Imperial China, Stanford University Press, Stanford, California, 2001; Kaye Soon Im, *The Rise and Decline of the eight Banner Garrisons in the Qing Period (1644-1911): A Study of the Kuang-chou, Hang-chou, and Ching-chou Garrisons*, Ph.D. diss., University of Illinois, 1981; Margaret Nowak, Stephan Durrant, *The Tale of the Nishan shamaness*, University of Washington Press, Seattle and London, 1977.

⁵⁴) Evelyn Rawski 1998, p. 129.

⁵⁵) Jennifer Holmgren, *Imperial Marriage in the Native Chinese and Non-Han state*, Han to Ming, in Marriage and Inequality in Chinese Society, ed. Rubie S. Watson, Patricia B. Ebrey, Berkeley 1991, pp. 58-96; Evelyn S. Rawski 1998, pp. 127-159.

⁵⁶) *Jiu Manzhou dang*, 1969, Vol. X; Daijing gurun-i uheri qooli, 60 дэвтэр, *Чэ өгч өргөмжилсөн нь* хэсэгт ёслолын зүйлийн дүрмийг тодорхой өгүүлсэн байдаг.

оролцуулсан "Дайчин төрхийн урлал" гэж хэлэх байна. Ийн чадсан тэдний бүтээлийг онож нэрлээ гэхүл, манж хэл, сэтгэхүйн эрхэм хэллэгийн нэг болох "туйлд хүрсэн" (ma-ten-de isinaha) гэдэг үгээр илэрхийлмээр байна.

НОМЗҮЙ

- Баярсайхан М. (2007), *Монгол, манж албан бичгийн харьцаа*, Acta Mongolica, МУИС, Монгол судлалын төв, Улаанбаатар, Том. 7 (291), т. 155-170.
- Баярсайхан М. (2008), *Жүрчин ба манжийн зарим цол хэргэмийн учир*, Солонгосын балар эртний соёл, гарал үүслийн асуудал, хурлын эмхтгэл, Улаанбаатар, т. 21-48.
- Ганбаатар Ц., Дэлгэржаргал П (2006), *Чингис хаанаас Чанчунь бумбад илгээсэн харагчин хонин жилийн нэгэн зарлиг*, Studia Historica, Tom. XXXVI, Fasc.6., Улаанбаатар, т. 47-58.
- Гонгор Д. (1970), *Халх товчоон I*, Улаанбаатар.
- Гончигжав (2006), *Сүвд эрх хэмээгдэх шастир оршиг*, хөр. С. Амарбаяр, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 18, Улаанбаатар.
- Дайчин гүрний Дотоод яамны Монгол бичгийн гэрийн данс, I-XI, Эрхлэн хэвлүүлсэн А. Цанжид, хянан тохиолдуулсан Ж. Болдбаатар, З. Лонжид, эх бичгийн судалгааг удирдан ажилласан Ш. Чоймаа, орчуулга, хөрвүүлэг, тайлбар хийсэн М. Баярсайхан, Т. Отгонтуул, Э. Мөнх-Учрал, С. Амарбаяр (2010) Соёмбо принтинг, Улаанбаатар.
- Жанчив Ё. (2008), *Монголчуудын зарим цол хэргэмийн учир*, Солонгосын балар эртний соёл, гарал үүслийн асуудал, хурлын эмхтгэл, Улаанбаатар, т. 54-110.
- Копан, Жан (2007), *Угсаатан судлал, хүн судлалын удиртгал*, орчуулсан С. Дулам, Битпресс, Улаанбаатар.
- Очир А. (1993), *Монголын Ойрадуудын түүхийн товч*, Улаанбаатар.
- Рашпунцаг (2006), *Болор эрх*, хөр. М. Баярсайхан, Ч. Нэргүй, Д. Бүдсүрэн, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 14, Улаанбаатар.
- Сагансэцэн (2006), *Эрдэнийн товч*, хөр. М. Баярсайхан, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 8, Соёмбо принтинг, Улаанбаатар.
- Сүхбаатар На. (2001), *Ойрад Монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд*, Улаанбаатар, Соёмбо принтинг.
- Хидэхиро, Окада (2012), *Дэлхийн түүх мэндэлсэн нь*, орчуулсан Наранбаяр, Инжинаш хэвлэлийн газар, Улаанбаатар.
- Чоймаа Ш. (2006), *Монголын нууц товчоон*, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 1, Соёмбо принтинг, Улаанбаатар.
- Чоймаа Ш. (2006), *Хаадын үндсэн хураангуй алтан товч*, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, 5, Соёмбо принтинг, Улаанбаатар.

愛新觉罗(AisinGioroUlrichun), 乌拉春, 滿族古神話, 蒙古人民出版社, 呼和浩特, 1987.

Allan, Sarah (1991), *The shape of the turtle: Myth, Art, and Cosmos in early China*. State University of New York Press. USA.

Badai, Altan-Orgil, Erdeni (1985), *Oyirad teьken surbulji bičig*, ЦМСККQ.

- Boyle, John A. (1956), *On the Titles given in Juvaini to Certain Mongolian Princes*, HJAS, Vol.19, No.1/2 (Jun., 1956), pp.146-54.
- Brunnert, H. S., Hagelstrom, W. V. (1911), *Present day Political Organization of China*, trans. by A. Beltchenko, E. E. Moran, Fuuchow.
- 舊滿洲檔 (*Jiu Manzhou dang*) photoreprint, Taipei, Palace Museum, 1969.
- Cleaves, F. W. (1960-1961) *The Sino-Mongolian inscription of 1240*, Harvard Journal of Asiatic Studies, Vol.23.
- Cleaves F. W. (1982), *The Secret History of the Mongols*, v. I, Cambridge.
- Daičing gurun-i uheri qooli
Dayičing гүрэн-и Dotuyadu yamun-u Mongγol bičig-ын ger-ын dangsa. I-XXII, Dumdadu ulus-un Төсө-ийн нигедьгер ариб, Арад-un yeke surγayuli-yin ulus-un Түб азий-a-yin kele төсө судулqu кэрийелeng, I-XIII debter, ЦМАКQ, 2010.
- Dunnell, Ruth; Millward James A (2003), *Introduction*, New Qing Imperial History, The making of Inner Asin Empire at Qing Chengde, eds. James Millward et al., Routledge Curzon, London, New York, pp.1-12.
- Eldendei, Ardajab (1986), *Mongγol-un niyuča tobčiyān, Seyiregьлl tayilburi*, ЦМСKKQ, Күкеqota.
- Elliot, Mark C. Chia, Ning (2003), *The Qing Hunt in Mulan*, New Qing Imperial History, The making of Inner Asin Empire at Qing Chengde, Routledge Curzon, London, New York, pp. 66-83.
- Elliot Mark C. (2001), *The Manchu Way*, The Eight Banners and Ethnic Identity in Late Imperial China, Stanford University Press, Stanford, California.
- Haenisch, Erich (1926), *Hošoi cin Wang*, Asia Major3, Harrassowitz, Wiesbaden, pp.589-591.
- Holmgren, Jennifer (1995), *Marriage Kinship and Succession under the Ch'i-tan Rulers of the Liao Dynasty (907-1125)*, T'ong Pao 72, 1986, pp. 44-91; Jennifer Holmgren, *Marriage, Kinship and Power in Nothern China*, Variorum, Galliard Ltd., Great Britain, pp. 44-91.
- Holmgren, Jennifer (1995), *Imperial Marriage in the Native Chinese and Non-Han state, Han to Ming*, Marriage and Inequality in Chinese Society, ed. Rubie S. Watson, Patricia B. Ebrey, Berkeley 1991, 58-96; Jennifer Holmgren, *Marriage, Kinship and Power in Nothern China*, Variorum, Galliard Ltd., Great Britain, pp. 58-96.
- Hummel, Arthur W. (1964), ed. *Eminent Chinese of the Ch'ing Period*, (1944-1912), Originally printed by US Government Printing Office, Washington, 1943-44, Reprinted by Literature House, LTD. 143 Chungking South Road, Section I, Taipei, Taiwan, Republic of China.
- Kaye Soon Im (1981), *The Rise and Decline of the eight Banner Garrisons in the Qing Period (1644-1911): A Study of the Kuang-chou, Hang-chou, and Ching-chou Garrisons*", Ph.D. diss., University of Illinois.
- Lattimore, Owen (1951), *Inner Asian Frontiers of China*, American Geographical Society, Research series No. 21, New York, 1940, second edition.
- Ligeti Lious (1958), *Deux tablettes de T'ai-tsoung des Ts'ing*, Acta Orientalia Hungaria. VIII, pp. 201-239.
- Michael, Franz (1965), *The Origin of Manchu name in China*, Frontier and Bureaucracy as Interacting Forces in the Chinese Empire, Octagon books. INC., New York.
- Millward, James A (2003), Dunnell, Ruth W., Elliot, Mark C., Foret, Philippe, eds., *New Qing Imperial History*, The making of Inner Asin Empire at Qing Chengde, Routledge Curzon, London, New York.

- Miyawaki, Junko (1987), *Did a Dzungar Khanate really exist?*, Journal of the Anglo-Mongolian Society 10:1-5.
- Miyawaki, Junko (1990), *On the Oyrat khanship*, Aspects of Altaic Civilization: Proceedings of the Thirtieth Meeting of the Permanent International Altaistic Conference, D. Sinor (ed.), Indiana University, Bloomington, Indiana, June 19-25, Bloomington, Indiana University Press, pp.142-153.
- Nowak, Margaret; Durrant, Stephan (1977), *The Tale of the Nishan shamaness*, University of Washington Press, Seattle and London.
- Perdue, Peter C. (2005), *China Marches West*, The Qing conquest of Central Eurasia, The Belknap Press of Harvard University Press, Cambridge, Massachusettes London, England.
- Rachewiltz, Igor de (2004), *The Secret History of the Mongols*, A Mongolian Epic Chronicle of the Thirteenth century, Vol.1-2, Brill, Leiden-Boston.
- Rawski, Evelyn S. (1991), *Qing Imperial Marriage and Problems of Rulership*, Marriage and Inequality in Chinese Society, ed. Rubie S. Watson, Patricia B. Ebrey, Berkeley, pp.170-203.
- Rawski, Evelyn S. (1998), *The Last Emperors: A Social History of Qing Imperial Institutions*. Berkeley, CA: University of California Press.
- Sary, Giovanni (1984), *The Manchu Emperor Abahai: Analysis of an Historiographic mistake*, CAJ 28, pp. 296-299.
- Serruys, Henry (1955), *Sino-Jürčed Relations During the Yung-Lo Period, (1403-1424)*, Güttinger Asiatische Forschungen, Band 4, Otto Harrasowitz, Wiesbaden.
- Serruys, Henry (1960), *Four Documents relating to the Sino-Mongol Peace of 1570-1571*, Monumenta Serica 19, pp.1-60.
- Serryus, Henry (1974), *Two remarkable women in Mongolia: The Third Lady Erketü qatun and Dayičing-beyiji*, Asia Major, Vol. XIX, pp.191-245.
- Ulayan (2005), *Erdeni-yin tobči-yin sudulul*, orčiyuluysan Altanbayan-a.

ABSTRACT

This paper is related to the noble titles of Manchus. The Manchus' relations with their Mongol allies were crucial for strengthening their state from its early years. Nurhaci, the chieftain of a Jurchen tribe in Jianzhou, received the title *Sečen kɔndɔlen qan* in 1606 instead of his clan title *Sure beile* (wise prince). By 1616, he had sufficiently consolidated himself in Jianzhou to proclaim himself as Khan of the Great Jin as a successor from previous Jurchen dynasty. Therefore, many works on Qing studies mention that this action raised his claims from a clan leader to the level of a Central Eurasian Khan. However, these works are lacking Manchu-Mongolian comparative studies on this matter, including titles given not only to the imperial man but women as well.

In the reign of Kangxi (1691), the court confirmed the titles for Khalkha princes. At that time, some titles such as *qungtayiji*, *jinong*, *ɔyijen*, *dayičing* were lost from the Qing dynasty's hierarchal system but *qan*, *wang*, *tayiji* were preserved. The title *qan* (Khan) meant an

‘Emperor of Mongol State.’ In connection with this it is hard to understand why the Manchus allowed keeping the title *qan* for the Mongols. The reason of preserving a *qan* title for the Mongols and Mongolian influence on Manchus’ titles are discussed within the frame of this paper.

The main focus is based on two points: title to claim the Mandate of Heaven (*beile, han, huangdi*) and titles to claim for Imperial family members. As for the first one, a change in the meaning of *qan* title is studied. Nurhaci's imperial ambitious program that was started by the acquisition of the Mongolian *qan* title can be justified. He and his successor Hongtaiji used a *qan* title to connect themselves to Chinggis Khan, and to win a prospect to become a ‘Khan.’ Later, they claimed to be a Huangdi, Emperor of Chinese World: a dream which was fulfilled after their conquest of Beijing. Actually, this title served them as an ‘Emperor of the World.’

The titles for imperial family members are considered in the second part. The main body of this discussion is related to the status of imperial women. They were divided to eight ranks, the top was Huanghou. The highly stratified imperial harem seems to have a Han Chinese structure that Manchu rulers adopted in the course of the seventeenth century. However, recent works strongly argue against the sinicization of the Manchus and put it forward as Manchus’ own nature or Manchu identity. In this viewpoint, the use of Chinese titles (*ujin* and *fei*) for imperial women in both early Manchu and Mongolian cases are discussed, which gives a chance of summing that titles were not alien or new things at that time; they were already transferred into common Manchu-Mongolian-Chinese multi-cultural background.

To conclude, the Manchu Emperor and his family members had the titles and ranks of Chinese origin, but they did not directly mirror the system. Moreover, the rank system was used as a mask. In comparison with early Manchu and Mongol titles, the ‘masking’ idea was not only appeared as Chinese character, but also it was an art of Manchu images that contained along with Manchu also Mongolian elements.